

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

№	ЗОРИЛТ	АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ХЭРЭГЖИЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ
1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;</p>	<p>-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.</p>	<p>ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ХЭРЭГЖИЛТ</p> <p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн хэвлэмэл болон хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллах бүх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд шуурхай, түгээж, цахим хуудасны нүүр хэсэгт байгууллагын холбоос, авлигаас урьдчилан сэргийлэх санал хүсэлтийн форм, богино хэмжээний шторкуудыг байршуулсан байна.</p> <p>Байгууллагын цахим хуудасны <a href="http://www.uda.ub.gov.mn">www.uda.ub.gov.mn</a> Хууль эрх зүйн буланд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг байршуулан олон нийтэд нээлттэй сурталчлан ажиллав.</p> <p>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системийн холбоос, болон “Авлигын эсрэг хамтдаа” таныг сонсож байна буланг тогтмол ажиллуулж байна.</p> <p>Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан мэдээллийн самбарыг шинэчлэн байршуулав. Зарцуулсан төсөв 600,000 мянган төгрөг.</p> <p>Авлигатай тэмцэх газраас гаргасан Соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Авлигыг мэдээл 110” - “Зөв зөвд Шударга зөв наалтыг байгууллагын 11 албан тасалгааны өрөөний үүдэнд байршуулсан.</p> <p>Нийгмийн сүлжээгээр бүх албан хаагчид бусадтай мэдээллийг хуваалцаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- <a href="https://fb.watch/IKlhdytO53/">https://fb.watch/IKlhdytO53/</a></li> <li>- 230216 avligiin gemt hereg 2-4 ok.mp4</li> <li>- <a href="https://iaac.mn/post/104859">https://iaac.mn/post/104859</a></li> <li>- <a href="https://www.youtube.com/watch?v=izAE3iIHnyQ&amp;t=1s">https://www.youtube.com/watch?v=izAE3iIHnyQ&amp;t=1s</a></li> <li>- ATG_HOM_SHTORK_OK3.mp4</li> </ul>	100

	<p>1.2. Авлигын эсрэг нөлөөллийн хэмжээг дэвсгэрийн байгууллага, салбарын тохируулан зохион байгуулах;</p>	<p>-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн жил ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын талаарх онолын болон практик судалгаа, дүн шинжилгээг хөгжүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн "Шударга ёс" онол арга зүйн 2023 оны сэтгүүлийг түгээн сурталчилан ажиллав.</p> <p><a href="http://www.facebook.com/groups/1873355006275950/posts/3550320638579370">www.facebook.com/groups/1873355006275950/posts/3550320638579370</a>  <a href="https://ferp.ulaanbaatar.mn/#/home/64ba2f70fc2e4165ff9be42">https://ferp.ulaanbaatar.mn/#/home/64ba2f70fc2e4165ff9be42</a></p>	<p>100</p>
<p>1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;</p>	<p>-Мэдээллийг сар бүр шинэчлэх;  -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбараар байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сурталчлан холбогдох мэдээллийг байршуулав. Үүнд:  Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ сар бүр (сарын мэдээ) Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ сар бүр (эхний 5 сарын мэдээ)  "Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх аян"-ны удирдамж Авлигатай тэмцэх газраас санаачлан гаргасан "ИРГЭН ТАНД" хуудасны мэдээлэл,  <a href="https://www.facebook.com/groups/1873355006275950">https://www.facebook.com/groups/1873355006275950</a>  Авлигатай тэмцэх газрын Facebook хуудасны "ЭБАТ Мэдээлэл" хэсгээс цаг үеийн болон сургалт, зохион байгуулалтын бусад арга хэмжээний мэдээллийг тухай бүр авч ажиллав.</p>	<p>100</p>	
<p>1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зураг, хуудас, сонин, нийтлэл, контент, хэвлэмэл ном, гарын авлага, брөюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж</p>	<p>-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;  -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц,</p>	<p>Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт "Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй" гэж заасны дагуу албан хаагчид хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв, хариуцлагатай мэдүүлэхийг анхаарч, Авлигатай тэмцэх газраас гаргасан ХАСХОМ гаргах зөвлөмж, зааварчилгаа, мөн Мэдүүлэг гаргагч нарт зориулсан зааварчилгааг тухай бүр нийт албан хаагчдад хүргэж ажиллав.</p> <p><a href="https://www.youtube.com/watch?v=tGN5w6c1S6E">https://www.youtube.com/watch?v=tGN5w6c1S6E</a>  <a href="https://www.youtube.com/watch?v=n2ppLugFY6E">https://www.youtube.com/watch?v=n2ppLugFY6E</a>  <a href="https://www.youtube.com/watch?v=eU6imNht7oWw">https://www.youtube.com/watch?v=eU6imNht7oWw</a>  <a href="https://www.youtube.com/watch?v=OxtvXmRDpOk">https://www.youtube.com/watch?v=OxtvXmRDpOk</a></p> <p>2024 оны хувьд мэдүүлгийг гаргуулах үйл явц нь цагаан сарын баярын өдрүүдтэй давхцаж байгааг анхаарч, 2024 оны 02 дугаар</p>	<p>100</p>	



		<p>олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.</p>	<p>сарын 01-14-ний өдрүүдэд системийн ачаалал ихсэж, гацах, алдаа заах зэрэг асуудал гарч болзошгүй талаар 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор багтаан мэдүүлэх чиглэлийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлснийг нийт албан хаагчдад хүргэж ажиллав. <a href="https://www.facebook.com/groups/1873355006275950">https://www.facebook.com/groups/1873355006275950</a></p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системд байршуулж, сурталчилсан хэвлэмэл хуудас, уриалгыг дэмжин ажиллав. Үүнд "АВЛИГААС ТАТГАЛЗАХ БОЛОМЖ БИДЭНД БИЙ", "ЭРҮҮЛ НИЙГЭМД ИРГЭН ТАНЫ, АЖИЛТАН МИНИЙ ОРОЛЦОО ЧУХАЛ" 110 утас руу үнэгүй залгах боломжтой", "АВЛИГА ӨГӨХӨӨС, АВАХААС ТАТГАЛЗЬЯ".</p> <p>Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар татвар ногдуулах орлого олсон иргэн бүр 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Татварын албанд тайлангаа ирүүлэх үүрэгтэй. Төрийн албан хаагч Таны татварын тайлангийн мэдээлэл ХАСХОМ дээрх өөрийн орлогын мэдүүлэгтэй тохирч байх талаар <a href="http://www.etax.mfa.mn">www.etax.mfa.mn</a> цахимаар тайлагнаж анхаарч ажиллах талаар мэдээлэл хүргүүлсэн.</p> <p>Хот байгуулалт, хотын стандартын газрын Ес зүйн дэд хорооноос уриалга зөвлөмж гарган нийт албан хаагчдад танилцуулж, газрын фэйсбүүк цахим хуудаст байршуулав.</p> <p><a href="https://www.facebook.com/groups/1873355006275950">https://www.facebook.com/groups/1873355006275950</a></p>
<p>2</p>	<p>Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулах</p>	<p>2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;</p>	<p>-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Албан хаагчдад зориулсан ажлын байран дахь сургалтын хөтөлбөрийг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Газрын даргаар батлуулав. Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "2023 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах тухай, анхаарах асуудал", "Авлигын эсрэг хуульд заасны дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар баталсан "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай" 5 дугаар тогтоолын танилцуулга", "Хууль эрх зүй - Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга", "Төрийн албан хаагчийн ёс зүйн</p>

			<p>зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" сэдэвт 7 удаагийн сургалтад (танхимаар 3, цахимаар 4) 79 албан хаагч хамрагдсан байна.</p> <p>Eবাটা.ub.gov.mn геопортал, гар утасны аппликэйшн шинээр ашиглалтад оруулан авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулж 8 төрлийн 36 үйлчилгээг цахимаар хүн, хуулийн этгээдээс хүлээн авч байна. Хүн, хуулийн этгээд өөрийн илгээсэн хүсэлтийн явц, шийдвэрлэлтийг хянах боломжтой.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Журам, жагсаалт, загвар батлах тухай" 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт" 14 үйлчилгээг (дугаар 223-236) нийт 15 үйлчилгээг И-Монголи академи УТҮГ-тай хамтран Төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Нийтийн эдэлбэрийн газрыг хүн, хуулийн этгээдийн хөрөнгөөр тохижуулах, ашиглах, хамгаалах хүсэлтийг шийдвэрлэх</li> <li>2.Нийтийн эдэлбэр газарт авто зогсоол төлөвлөх, байгуулах хүсэлтийг шийдвэрлэх</li> <li>3.Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлт</li> <li>4.Гадна зар сурталчилгааны байгууламжийн загвар зураг батлах</li> <li>5.Барилгын ажил эхлүүлэх-Шинээр олгох</li> <li>6.Барилгын ажил эхлүүлэх-Сунгах</li> <li>7.Барилгын ажил эхлүүлэх-Нэмэлт өөрчлөлт оруулах (салгаж оруулсан)</li> <li>8.Барилгын ажил эхлүүлэх-Буулгах зөвшөөрөл</li> <li>9.Барилгын ажил эхлүүлэх-Цахилгааны ажлын зөвшөөрөл</li> <li>10.Барилгын ажил эхлүүлэх-Инженерийн шугам сүлжээний</li> <li>11.Инженерийн бэлтгэл арга хэмжээ үерийн далан суваг, хөрсний усны трасс зөвшилцөх, зөвшөөрөлдөх үйлчилгээ</li> <li>12.Мэдээлэл холбооны шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлдөх үйлчилгээ</li> <li>13.Дулаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлдөх үйлчилгээ</li> <li>14.Цахилгаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлдөх үйлчилгээ</li> <li>15.Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлдөх үйлчилгээ</li> </ol>
<p>2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хариуцдаг, хамтран хаммаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p>-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;  -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>100</p>	



					<p>Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Хот байгуулалтын дотоод үйл ажиллагаатай холбоотой (Нийтлэг үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээ, Хот байгуулалт, хөгжлийн газарт ирсэн гомдол болон шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх ажил гүйцэтгэх гэрээ, Callpro TEXT үйлчилгээний гэрээ, Callpro VOICE үйлчилгээний гэрээ, Хаан банк хамтран ажиллах гэрээ, Болор дуран программын хэрэглэгчийн эрх нийлүүлэх гэрээ, Ажил гүйцэтгэх гэрээ 3, Худалдах, худалдан авах 2 гэрээ, Цалингийн карт, зээлээр үйлчлэх гэрээ, Программ хангамжийн ажил гүйцэтгэх гэрээ, Бодит хурдны интернэт үйлчилгээ үзүүлэх гэрээ, Архив нүүлгэх ажлын 2 гэрээ, Программ хангамж нийлүүлэх гэрээ, Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Менежментийн тогтолцоонд анхдагч баталгаажуулалтын ажил гүйцэтгэх гэрээ, Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тухай хамтран ажиллах гэрээ, Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх гэрээ 2, сургалтын гэрээ 2, Дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээ) нийт 25 гэрээнд дараах 3 заалтыг тусган ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг хувийн хэрэгт хавсаргасан.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “энэхүү гэрээтэй холбоотой ажил гүйцэтгэх явдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй” гэж.</li> <li>2. “гэрээний үүрэг биелээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал нь барагдуулна” гэж тухайлсан гэрээний хариуцлага бүлэгт,</li> <li>3. “захиалагч тал нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд гүйцэтгэгч талын хийсэн ажлын төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй бөгөөд ажлын гүйцэтгэл 50 хувиас дээш гарсан тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхгүй болно” гэж гэрээний “Захиалагч тал” бүлэгт.</li> </ol>	100
3	<p>Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</p>	<p>3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;</p>	<p>-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;</p> <p>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;</p> <p>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;</p> <p>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;</p> <p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;</p> <p>-Сургалт, мэдээлэл авсан байх;</p>	<p>Хот байгуулалт, хотын стандартын газрын дотоод Хяналт шалгалтын ажлын 2024 онд 13 ажил хийхээр төлөвлөн төлөвлөгөө Газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний бүрдүүлбэр, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийх дотоод хяналт шалгалтын ажлын 2024/01 дугаартай удирдамж Газрын даргаар батлуулав. Удирдамжийн дагуу Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний бүрдүүлбэрт хяналт шалгалт хийх бөгөөд Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан “Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох”, 29 дүгээр зүйлд заасан “Барилгын ажлын</p>	100

4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1. Авлигын эрсдэл ба авлига боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат	-Үйл ажиллагаанд үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн хэрэгжүүлсэн байх. чиг авч, байх.	<p>зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээллийг тусгасан эсэх, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийг мөрдүүлж ажилласан эсэх, Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олголттой холбоотой өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн чанар, хугацааг шалгаж 2023 оны шалгалтын ажилтай харьцуулах мөн хүчингүй болон түдгэлзүүлсэн Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд дүн шинжилгээ хийх ажил хийгдэж байна.</p> <p>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, мэргэжил ур чадварын талаар гаргасан 51 өргөдөл, гомдлыг хууль, дүрэм, журам, барилгын норм дүрэм хангасан эсэх шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж Албаны шалгалт хийж хариу өгч шийдвэрлэв. Өргөдөл гомдлын дагуу Бөхбат ХХК, Аргамаг ХХК, А.Арамзоригт, Г.Пүрэвсүрэн, Ж.Бямбагэрэл, Дашваанжил ХХК, Уран проект ХХК, Хур алтан өргөө ХХК, Хадан-Уулс ХХК, иргэн Д.Дашжаргал, Тээвэр ачлал ХХК зэрэг компанийн төлөөлөл болон иргэдтэй барилгын үе шатны зөвшөөрлийн талаар удаа дараагийн уулзалтыг нийслэлийн Ерөнхий архитектор болон холбогдон нэгжийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан. Хяналт, шалгалтын газрын даргын 2024 оны А/10 дугаар тушаал, 02-13-01/023/01 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн 12 баршилд хяналт шалгалт хийсэн бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/161 дугаартай Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зург төсөлд хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай 7 заалт бүхий хот байгуулалтын тухай болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хуучин батлагдсан барилгажилтын төслийн зураг төслүүдийг дахин нягтлах, загвар зургийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж байх тухай албан бичгийн дагуу Барилга, хот байгуулалтын хэлтэст мөрдөж ажиллахыг даалгав.</p> <p>2024 онд шинээр байгуулсан 25 гэрээнд Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдэх хуудсыг гаргуулан ажилласан. Хот байгуулалтын гэрээ, түүний биелэлтийн явцын талаарх мэдээллийг газрын дотоод сүлжээнд тухай бүр байршуулж ажиллав.</p> <p>Z:\11.KHUULIN KHELTES4.DOTOOD AJILGEREE Z:\11.KHUULIN KHELTES4.DOTOOD AJILGEREE\HUT BAILGUULLALTIN GEEE\2024 ON</p>
				100



		<p>дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)</p> <p>4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;</p>	<p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх ;</p> <p>-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч "Барилгын салбарын бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт уулзалтыг нийслэлд үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын бизнес эрхлэгч, инженерийн байгууллагын төлөөлөл, иргэн, хуулийн этгээдийн удирдлагуудтай 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00-12.00 цагийн хооронд Монголын Хүүхдийн ордонд зохион байгууллаа. Уулзалтад оролцох 782 иргэн, хуулийн этгээдэд цахим урилга хүргүүлсэн бөгөөд 310 иргэн, хуулийн этгээдэд биечлэн оролцсон.</p> <p>2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газраас 2 дахь жилдээ зохион байгуулж буй "Явган замын хавтан, авто замын хашлагийн стандартыг мөрдүүлэх асуудлаар" нийслэлийн 9 дүүрэгтэй хийх уулзалтад тус газраас "Явган замын хавтан, авто замын хашлагатай холбоотой мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, зөрчлүүд" сэдвийн хүрээнд танилцуулга хийж оролцов.</p>	<p>100</p>
5	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх</p>	<p>5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад танилцуулах;</p>	<p>-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Газрын 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн ажлын тайланг нийт албан хаагчдад танилцуулж, 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцуулан эцэслэж Газрын даргаар 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр батлуулж ажиллав.</p>	<p>100</p>

	<p>5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;</p>	<p>-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэгт дурдсаны дагуу Авлигатай тэмцэх газарт Газрын ёс зүйн дүрмийн шинэчилэн боловсруулсан төсөлд санал авах тухай 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/10/3443 дугаартай албан бичгийг хүргүүлж, 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 04/20921 дугаартай албан бичгээр 17 заалтад ирүүлсэн саналыг тусгаж Газрын ёс зүйн дүрмийг батлуулахаар бэлтгэсэн болно.</p>	100
<p>5.3. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khutulbulg.iaas.mn (Авлигын эсрэг Үндэсний хөтөлбөр) цахим санд нэмж оруулсан байх, -Тайлагнасан байх.</p>	<p>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шил" ажиллагааны хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2023 оноос Нийслэлийн Ерөнхий архитекторын дэргэдэх хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн хурлыг иргэд, олон нийтэд нээлттэйгээр цахим хаягаар шууд дамжуулж, 40 удаагийн хурлыг цахимаар хийж ажиллав.</p> <p>Иргэн, хуулийн этгээдээс газарт утсаар хандан мэдээлэл, зөвлөгөө авах, мэргэжилтэнтэй холбогдох хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх хүрээнд "Операторын үйлчилгээ"-г нэвтрүүлэн дуудлага бүрд хариулан түргэн шуурхай үйлчилгээг харилцаа холбооны Коллпро ХХК-тай хамтран "Та залга бид хариулья" уриатайгаар 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс нэвтрүүлэн ажиллаж байна. Ингэснээр нэг ч дуудлага алдахгүй давуу талтай.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжаар байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн "Мэдээллийн цаг"-аар "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хууль, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-ийг тус тус нийт алба хаагчдад танилцуулж зөвлөмж хүргүүлэхээр сургалтын хөтөлбөр гарган бэлтгэсэн.</p>	100	
<p>5.3.1 Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил</p>	<p>- Ажлын хэсэг байгуулсан, хэн нэгэн албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилтэд үр</p>	<p>Газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гарсан А 40 тушаал, хүний нөөцийн чиглэлээр гарсан Б 54 тушаалын төслийн хууль зүйн үндэслэлтэй эсэхэд Хуулийн хэлтэс хяналт тавьж ажиллав. Газрын даргын тушаалаар баталсан байнгын үйл ажиллагаатай ажилладаг 8 ажлын хэсгийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, жилийн ажлын төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	100	



	<p>зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих (Жишээ нь: тушаал шийдвэр гаргахдаа үндэслэх хэсэгт хамааралгүй хууль, тогтоол, захирамжийг үндэслэн тушаал гардаг асуудлыг арилгахад чиглэсэн)</p> <p>5.3.2 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хугацаа хэтрүүлэхгүй байх, бодитой шийдвэрлэж хугацаанд нь зохих хариу өгөх ажлыг сайжруулах ажил зохион байгуулах. (Албан хаагчдын ёс зүйн зөрчил, дутагдал хамаарах)</p>	<p>дүнг тооцсон байх,</p> <p>-Үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх</p>	<p>Байгууллагын хэмжээнд нийт 2115 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэнээс албан хаагчтай холбоотой 5 гомдол хүлээн авсан, үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2 иргэний гомдлыг татуулж,</li> <li>• 1 иргэний гомдолд хариу тайлбарыг албан бичгээр хүргүүлж,</li> <li>• албан хаагчийн буруутай 1 гомдолд иргэнээс уучлал гуйж гомдлыг барагдуулсан.</li> <li>• Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 1 гомдолд үүссэн нөхцөл байдлын талаар тайлбар өгч ажиллав. W:12024</li> </ul> <p>Байгууллагын алба хаагчдад ёс зүйн зөрчлөөс ангид байх, цаашид сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх тал дээр цаг тухай бүрд зөвлөмж өгч ажилласан ба алба, хэлтсийн ахлах мэргэжилтнүүдэд цаг үеийн байдлаар мэдээлэл өгсөн.</p>	<p>100</p>
	<p>5.3.3 Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, Засгийн газрын тогтоолоор хүчин төгөлдөр бус болсон эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.</p>	<p>-Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох дүрэм, журмыг хяналтад авч, кодификаци хийсэн байх</p>	<p>Байгууллагын цахим хуудас дахь “Хууль, дүрэм журам” булан дахь хуулиуд, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, газрын даргын тушаалаар батлагдсан дүрэм журмын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсэхэд хяналт тавьж тогтмол шинэчлэлтийг хийн ажиллаж байна.</p>	<p>100</p>

	<p>5.3.4 Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах. (Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах, Нийслэл, Үндэсний аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар жил бүр илэрдэг санхүүгийн зөрчил, дутагдлыг цаашид гаргахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах)</p>	<p>-Төсөв, санхүүгийн зөрчилгүй ажиллах -Сүүлийн жилийн хугацаанд илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргаагүй байх</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр 2 албан шаардлага хүлээн авч, албан шаардлагын хэрэгжилтийг ханган цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, давтан гаргалгүй ажилласан.</p> <p>Батлагдсан төсвийг үр ашигтай төлөвлөн зарцуулж батлагдсан төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэлийг хийж ажиллав.</p>	<p>100</p>
--	---	--	---	------------



ТАНИЛЦСАН: ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА **Г.БАЯРСАЙХАН**

ХЯНАСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА **Д.ДАШЦЭЦЭГ**

ТАЙЛАН ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН **Т.БУЯНЖАРГАЛ**